



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**БИЗНЕСИЙН ТӨЛӨВИЙН
ТҮҮВЭР СУДАЛГАА**
2026 оны I улирал

2026 оны 5 дугаар сар



I. ХУРААНГУЙ

“Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2026 оны 4 дүгээр сард цуглуулж, 404 аж ахуйн нэгжийн мэдээлэлд үндэслэн судалгааны үр дүнг нэгтгэлээ.

- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй, аж үйлдвэрийн салбарын тэр дундаа хүнсний болон хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, 20-оос дээш жилийн туршлагатай, 200 хүртэл ажилтантай, 2.5 тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой байна.
- Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол:

<i>Аргачлал</i>	<i>2026 оны II улиралд</i>	<i>2027 оны I улиралд</i>
Дундаж утгаар	8.5%	9.3%
Медиан утгаар	8.3%	9.0%


- 2025 оны I улирлаас хойш гурван улирал дараалан буураад байсан инфляцын хүлээлтийн утга өнгөрсөн улирлаас өсч, энэ улирал нэмэгдлээ. Салбарын түвшинд харьцуулахад барилгын салбарын инфляцын хүлээлтийн утга ирэх улиралд 9.1%, ирэх 12 сард 9.9% буюу харьцангуй өндөр байв.
- **Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт:** 2026 оны I улиралд өмнөх улирлаас 12.1 нэгжээр буурч, **81.0** утгатай буюу агшилтын мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын болон хэрэглэгчийн бүх үзүүлэлтүүд муудсан нь эдийн засгийн идэвхжил, эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт сул байгааг илэрхийлж байна.
- **Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт:** 2026 оны I улиралд **86.3** нэгжид хүрч буурч, хөдөлмөрийн зах зээлийн талаарх хүлээлт суларчээ. Мөн өмнөх улиралтай харьцуулахад бүх салбарт ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт буурсан бөгөөд ялангуяа аж үйлдвэрийн салбарт хүлээлтийн үзүүлэлт огцом саарсан байна.
- **Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт:** 2026 оны I улиралд өмнөх улирлаас 7.4 нэгжээр өсөж, **139.9** нэгжид хүрсэн нь эдийн засгийн орчны талаарх тодорхой бус байдал нэмэгдсэнийг илтгэж байна. Салбарын ангиллаар авч үзвэл, худалдаа болон барилгын салбаруудад тодорхой бус байдлын үзүүлэлт хамгийн өндөр байгаа бөгөөд аж үйлдвэрийн салбараас бусад бүх салбарт өмнөх улирлаас нэмэгдээд байна.
- Ирэх улирлын эрэлт, экспортын хүлээлтүүд өмнөх улирлаас буурч, агшилтын мужид хадгалагдсан нь аж ахуйн нэгжүүдийн дунд эдийн засгийн идэвхжил саарах хүлээлт давамгайлж байгааг харуулж байна. Ялангуяа дотоод худалдааны салбарын үзүүлэлт огцом буурсан нь нийт индекс сулрахад голлон нөлөөлжээ.

II. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс үнийн ерөнхий түвшний өнгөрсөн үеийн өөрчлөлт болон цаашдын төлөвийн талаар асууж, үнийн мэдрэмжийн болон хүлээлтийн чиглэлийн индексийг тооцлоо. Үр дүнгээс харахад, өнгөрсөн 3 болон 12 сарын үнийн мэдрэмжийн индексийн утга өмнөх улирлаас бага зэрэг нэмэгдсэн байна. Үүнээс өнгөрсөн 3 сарын мэдрэмжийн индекс өмнөх улиралд “инфляц хэвэндээ” мужид байсан бол энэ улиралд “инфляц өссөн” мужид шилжээд байна. Харин өнгөрсөн 12 сарын мэдрэмжийн индекс “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 1).

Түүнчлэн ирэх 3 болон 12 сарын үнийн хүлээлтийн чиглэлийн индексийн утга өмнөх улирлаас мэдэгдэхүйц нэмэгдэж, индекс тус бүрийн утга “инфляц өснө” мужид шилжлээ (Зураг 2).

Зураг 1. Инфляцын мэдрэмжийн индекс



Зураг 2. Инфляцын хүлээлтийн индекс




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

ААН-үүдийн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тоон хариултад үндэслэн жигнэсэн дундаж утгыг тооцоход, 2026 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас 1.0 нэгж хувиар өсөж **8.5%**, 2027 оны I улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар өсөж **9.3%**-тай тус тус гарлаа. Харин инфляцын хүлээлтийн тоон хариултын медиан¹ утгыг тооцоход, 2026 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар өсөж **8.3%**, 2027 оны I улирлын хүлээлт мөн 0.5 нэгж хувиар өсөж **9.0%**-тай гарлаа (Зураг 3, Зураг 4).


Ийнхүү 2025 оны туршид гурван улирал дараалан буурах хандлагатай байсан инфляцын хүлээлт энэ улирлаас эргэн нэмэгдэж, богино болон урт хугацаанд зорилтот түвшнээс өндөр хадгалагдсан нь цаашид инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлтэйг харуулж байна.

¹ Тоон асуулгын хариултаас [Nicholas J. Cox \(2009\)](#)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

Зураг 3. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга, ирэх 3 сар



Зураг 4. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга, ирэх 12 сар




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


Ирэх 3 сарын инфляцын хүлээлтийн тархалтаас харахад, 2025 оны IV улиралд аж ахуйн нэгжүүдийн хүлээлт голлон 7–9 хувийн интервалд төвлөрч байсан бол 2026 оны I улирлын судалгаагаар тархалтын оргил 7 хувийн түвшин рүү шилжсэн байна. Үүний зэрэгцээ 9 хувийн түвшин дэх давтамж буурсан нь богино хугацааны инфляцын дарамтын талаарх төсөөлөл өмнөх улирлаас бага зэрэг суларчээ. Мөн хүлээлтийн тархалт харьцангуй төвлөрсөн хэлбэртэй болсон нь аж ахуйн нэгжүүдийн хүлээлтийн зөрүү багасаж, тодорхой бус байдал буурч байгааг харуулж байна (Зураг 5).

Ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн тархалтад мөн ижил өөрчлөлт ажиглагдав. Тухайлбал, 2025 оны IV улиралд хүлээлтийн оргил 9 хувьд төвлөрч, 11–13 хувийн өндөр түвшний хүлээлтүүд харьцангуй түгээмэл байсан бол 2026 оны I улиралд тархалт 7 хувийн орчимд илүү төвлөрч, 9-11 хувийн хүлээлтийн давтамж мэдэгдэхүйц буурсан байна. Гэсэн хэдий ч 11-с дээш хувийн хүлээлтийн давтамжууд багагүй нэмэгдсэн нь урт хугацаанд инфляцын хүлээлтэд тодорхой бус байдал нэмэгдэх дохио болж байна (Зураг 6).

Зураг 5. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 3 сар



Зураг 6. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 12 сар




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


Инфляцын хүлээлтийн утгыг салбарын ангиллаар авч үзвэл, аж ахуйн нэгжүүдийн ирэх 3 сарын инфляцын хүлээлт 2022 оны эхэн үеэс буурах хандлагатай байсан бөгөөд 2024 оны III улиралд хамгийн доод түвшинд хүрч байв. Харин түүнээс хойш бүх салбарт инфляцын хүлээлт дахин нэмэгдэж, 2026 оны I улирлын байдлаар зорилтот түвшнээс давсан хэвээр байна. Тухайлбал, барилгын салбарын хүлээлт 9.1% буюу хамгийн өндөр түвшинд гарсан бол худалдаа 8.6%, аж үйлдвэр 8.4%, үйлчилгээний салбар 8.1% харьцангуй бага түвшинд байна. Энэ нь богино хугацаанд бүх салбарт үнийн өсөлтийн дарамт хадгалагдаж байгааг, ялангуяа барилгын салбарт өртөг зардлын нөлөө өндөр байгааг илтгэж байна (Зураг 7).

Ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн хувьд мөн адил 2024 оны III улиралд хамгийн бага түвшинд хүрсний дараа өсөх хандлага ажиглагдав. 2026 оны I улиралд барилгын салбарын хүлээлт 9.9% буюу хамгийн өндөр түвшинд байгаа бол аж үйлдвэр 9.5%, худалдаа 9.1%, үйлчилгээний салбар 9.0%-тай гарлаа. Урт хугацааны хүлээлтүүд богино хугацааныхаас бүх салбарт өндөр байгаа нь аж ахуйн нэгжүүд инфляцын дарамт цаашид үргэлжилнэ гэж төсөөлж байгааг харуулна (Зураг 8).

Зураг 7. Инфляцын хүлээлтийн дундаж утга, салбараар (ирэх 3 сар)



Зураг 8. Инфляцын хүлээлтийн дундаж утга, салбараар (ирэх 12 сар)



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


Аж ахуйн нэгжийн хэмжээгээр² авч үзвэл, ирэх 3 болон 12 сарын инфляцын хүлээлт 2022 оноос хойш буурах хандлагатай байснаа 2024 оны III улиралд хамгийн бага түвшинд хүрсний дараа дахин өсөж, 2026 оны I улиралд зорилтот түвшнээс давсан хэвээр байна. Богино хугацааны буюу ирэх 3 сарын хүлээлтийн хувьд бичил бизнесийн хүлээлт 9.3% буюу хамгийн өндөр байгаа бол жижиг бизнес 8.8%, дунд бизнес 8.3%, том бизнес 7.5%-тай гарчээ (Зураг 9). Харин ирэх 12 сарын хүлээлтэд бичил бизнесийн хүлээлт 9.9% буюу хамгийн өндөр хэвээр байгаа бол жижиг болон дунд бизнесүүдийн хүлээлт 9% орчим, том бизнесийнх 8.6% буюу харьцангуй бага түвшинд байв (Зураг 10).

Эдгээр үр дүнгээс харахад бичил болон жижиг бизнесүүд инфляцын өсөлтөд илүү мэдрэмтгий байгаа нь өртөг, орлого болон үнийн хэлбэлзлийн нөлөөг илүү хүчтэй мэдэрч байгаатай холбоотой байж болох юм. Харин том бизнесүүдийн инфляцын хүлээлт харьцангуй бага байгаа


² “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуульд тусгагдсан борлуулалтын орлогын зааг утгаар ангилав. Тодруулбал, жилийн 300 сая төгрөг хүртэл орлоготой бол “Бичил”, 300 саяас 1.0 тэрбум төгрөг хүртэл “Жижиг”, 1.0-2.5 тэрбум төгрөг бол “Дунд”, 2.5 тэрбум төгрөгөөс дээш бол “Том” ангилалд хамааруулав.

нь эдийн засгийн өөрчлөлтөд илүү тогтвортой дасан зохицох чадвартай байгааг илтгэж байна. Ерөнхийдөө, бүх төрлийн аж ахуйн нэгжийн инфляцын хүлээлт зорилтот түвшнээс өндөр хэвээр байгаа нь инфляцын дарамт үргэлжлэх хүлээлт хадгалагдаж байгааг харуулна.

Зураг 9. Инфляцын хүлээлтийн дундаж утга, хэмжээгээр (ирэх 3 сар)




Зураг 10. Инфляцын хүлээлтийн дундаж утга, хэмжээгээр (ирэх 12 сар)




Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

Аж ахуйн нэгжүүдийн туршлагын ангиллаар инфляцын хүлээлтийн динамикийг авч үзвэл, ирэх 3 сарын хүлээлт 2022 оны эхэнд өндөр (11–12%) түвшинд байсан бөгөөд 2023 оны II улиралд бүх бүлэгт 4–5 хувь хүртэл буурсан байна. Харин 2025 оны эхнээс дахин өсөх хандлага ажиглагдаж, 2026 оны I улирлын байдлаар 8.3–8.5 хувийн түвшинд хүрч, бүх бүлэгт ойролцоо түвшинд тогтсон байна (Зураг 11). Урт хугацааны буюу ирэх 12 сарын хүлээлтийн хувьд мөн ижил чиг хандлага ажиглагдаж, 2024 оны III улиралд ~5 хувь хүртэл буурсан ч 2026 оны I улиралд 9.1–9.5 хувьд хүрч өссөн нь бүх бүлэгт инфляцын дарамт дахин нэмэгдсэнийг илтгэж байна (Зураг 12).

Зураг 11. Инфляцын хүлээлтийн дундаж утга, туршилагаар (ирэх 3 сар)



Зураг 12. Инфляцын хүлээлтийн дундаж утга, туршилагаар (ирэх 12 сар)



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


III. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI³)


Монгол Улсын эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлаас 12.1 нэгжээр буурч, 2026 оны I улиралд **81.0** нэгжтэй гарснаар агшилтын мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 13). Энэхүү үзүүлэлт нь сүүлийн дөрвөн жилийн хамгийн доод түвшинд хүрсэн бөгөөд салбарын индексүүдийг авч үзвэл хэрэглэгч (96.1), барилга (78.6), үйлчилгээ (78.2), аж үйлдвэр (76.9), дотоод худалдаа (72.3) зэрэг бүх салбарын үзүүлэлт 100-аас доош буюу агшилтын мужид байна.

Мөн өмнөх улиралтай харьцуулахад нийт салбарын үзүүлэлтүүд муудсан дүр зураг ажиглагдав. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын индекс 17.3 нэгжээр, барилгын салбар 12.5 нэгжээр, үйлчилгээний салбар 10.8 нэгжээр, дотоод худалдааны салбар 7.2 нэгжээр, хэрэглэгчийн үзүүлэлт 4.6 нэгжээр тус тус муудсан байна (Зураг 14). Өөрөөр хэлбэл, эдийн засгийн идэвхжил саарч, аж ахуйн нэгжүүд болон хэрэглэгчдийн эдийн засгийн төлөвийн талаарх үнэлгээ сул хэвээр байна.

Зураг 13. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт



Зураг 14. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт, салбараар



Тэмдэглэл: Энэхүү үзүүлэлт нь эдийн засагт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, эдийн засгийн нөхцөл байдал), барааны нөөц, ирэх 3 сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар тодорхойлогдох бөгөөд Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалд тулгуурлан тооцлоо. Үзүүлэлт 100-с дээш гарах нь эдийн засгийн нөхцөл байдал сайжрах, 100-с бага бол эдийн засгийн нөхцөл байдал муудах төлөвийг илэрхийлнэ.

Тэмдэглэл: Төвөөс алслагдсан утга нь тухайн үзүүлэлт сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайлангийн аргачлалыг жишиг болгон аж үйлдвэр 40%, үйлчилгээ 30%, хэрэглэгч 20%, барилга 5%, дотоод худалдаа 5%-иар жигнэн тооцсон болно.

Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


³ Economic Sentiment Index

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI⁴)


Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт болон бодит үзүүлэлтийг харьцуулан авч үзвэл, 2022 оны эхнээс 2025 оны II улирал хүртэл хүлээлт болон бодит гүйцэтгэл ерөнхийдөө өсөх хандлагатай байж, тухайн хугацаанд хамгийн өндөр түвшинд хүрч байв. Харин үүнээс хойш эдгээр үзүүлэлтүүд саарч, 2026 оны I улиралд хүлээлтийн үзүүлэлт **86.3** түвшинд хүрч буурсан бол ажил эрхлэлтийн бодит үзүүлэлт өмнөх улирлын хүлээлтээс доогуур түвшинд гарлаа (Зураг 15). Энэ нь аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн зах зээлийн талаарх хүлээлт суларч, ажил эрхлэлтийн бодит байдал хүлээлтэд хүрэхгүй байгааг илэрхийлж болох юм.

Тус үзүүлэлтийг салбарын ангиллаар авч үзвэл, 2026 оны I улиралд өмнөх улирлаас бүх салбарын хувьд буурсан дүр зурагтай байв. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын хүлээлт огцом буурч, өмнөх улиралд өндөр түвшинд байсан үзүүлэлтүүд мэдэгдэхүйц саараад байна (Зураг 16).

Зураг 15. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 16. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт, салбараар



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

Эдийн засгийн тодорхой бус байдал (EUF⁵)


Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлын талаарх аж ахуйн нэгж, иргэдийн үнэлгээнд үндэслэн тооцсон хүлээлтийн үзүүлэлт 2026 оны I улиралд өмнөх улирлаас 7.4 нэгжээр өсөж, **139.9** утгатай гарлаа (Зураг 17). Өөрөөр хэлбэл, эдийн засгийн орчны талаарх тодорхой бус байдал нэмэгдэж, цаашдын төлөвт итгэх итгэл суларч байна.

Салбарын ангиллаар авч үзвэл, эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт дотоод худалдааны салбарт хамгийн өндөр буюу 158.5 утгатай гарсан бол хэрэглэгчийн бүлэгт 154.5, барилгын салбарт 152.4, үйлчилгээний салбарт 141.7, аж үйлдвэрийн салбарт 127.4 нэгжтэй тус тус байна. Өмнөх улиралтэй харьцуулахад аж үйлдвэрийн салбараас бусад бүх салбарын үзүүлэлт өссөн нь эдийн засгийн нөхцөл байдлын талаарх эрсдэл, тодорхой бус байдлын төсөөлөл нийтлэг нэмэгдсэнийг харуулж байна (Зураг 18).


⁴ Employment Expectation Index

⁵ Economic Uncertainty Index

Зураг 17. Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт



Зураг 18. Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт, салбараар



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа


IV. БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ирэх улирлын эрэлтийн хүлээлт өмнөх улирлаас 15.1 нэгжээр буурч, 89.7 утгад хүрснээр бүх салбарт агшилтын мужид шилжлээ. Ингэснээр нэг улирлын дараа эргэн агшилтын мужид орсон бөгөөд аж ахуйн нэгжүүдийн дунд ирэх хугацаанд эрэлт мэдэгдэхүйц сулрах хүлээлт давамгайлж байна (Зураг 19). Мөн ирэх улирлын экспортын хүлээлт өмнөх улирлаас 1.4 нэгжээр буурч, 96.7 утгатай буюу агшилтын мужид хэвээр хадгалагдлаа. Салбарын түвшинд авч үзвэл дотоод худалдааны салбарын үзүүлэлт хамгийн ихээр буурсан нь нийт индекс сулрахад голлон нөлөөлжээ (Зураг 20).


Нөгөө талаас, зардлын дарамттай холбоотой хүлээлтүүд эрчимтэй нэмэгдэв. Тодруулбал, ирэх улирлын ажиллах хүчний зардлын хүлээлт өмнөх улирлаас 11.1 нэгжээр өсөж, 159.8 утгатай буюу өндөр түвшинд хэвээр хадгалагдсан бөгөөд барилга, аж үйлдвэр болон дотоод худалдааны салбаруудад өсөлт илүү хүчтэй ажиглагдлаа (Зураг 21). Түүнчлэн нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 25.5 нэгжээр өсөж, 179.2 утгад хүрсэн нь бүх салбарт суурь өртөг эрчимтэй нэмэгдэж байгааг харуулна (Зураг 22).

Үүнээс гадна ирэх улирлын ханшийн хүлээлт өмнөх улирлаас 18.9 нэгжээр өсөж, 157.0 утгатай буюу төгрөг сулрах мужид хэвээр хадгалагдсан бол зээлийн хүүний хүлээлт сүүлийн гурван улирал дараалан буурсан хандлагыг эвдэж, 17.5 нэгжээр өсөн 135.3 нэгжид хүрч, зээлийн хүү өсөх мужид хэвээр гарлаа (Зураг 23, Зураг 24). Ерөнхийдөө, эрэлтийн хүлээлт суларч буйтай зэрэгцэн зардал, ханш болон санхүүжилтийн дарамтын хүлээлтүүд огцом нэмэгдсэн бөгөөд дийлэнх үзүүлэлтүүд сүүлийн дөрвөн жилийн хамгийн сул түвшинд хүрсэн нь эдийн засгийн орчинд эрсдэл нэмэгдэж буйг илтгэх анхаарах дохио болж байна.


Зураг 19. Эрэлтийн хүлээлт




Зураг 20. Экспортын хүлээлт



Зураг 21. Ажиллах хүчний зардлын хүлээлт




Зураг 22. Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлт



Зураг 23. Ханшийн хүлээлт



Зураг 24. Зээлийн хүүний хүлээлт



Эх сурвалж: Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа

V. ХАВСРАЛТ 1: Аж ахуйн нэгжүүдийн ерөнхий мэдээлэл

Тус түүвэр судалгааг 2026 оны 4 дүгээр сард аж ахуйн нэгжүүдийн дунд явуулж, нийт 404 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан бөгөөд өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 377 (93%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 17 (4%) нь хувьцаат компани (ХК), үлдсэн 10 (2%) нь бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй ААН-үүд байна (Хүснэгт 1).

Хувийн хэвшлийн ААН-үүд судалгаанд голлон хамрагдсан бөгөөд тэдгээрийн 44% нь 20-с дээш, 26% нь 15-20 жил, 15% нь 10-15 жил, 12% нь 5-10 жил турш үйл ажиллагаа эрхэлсэн ААН-үүд байна (Хүснэгт 2). Ерөнхий салбараар авч үзвэл аж үйлдвэр болон үйлчилгээний салбарын тус бүр 138 (34%), худалдааны салбарын 65 (16%), барилгын салбарын 63 (16%) ААН тус тус хамрагдлаа (Хүснэгт 3).

Жилийн борлуулалтын орлогын ангиллар авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 187 (46%), 1.0-2.5 тэрбум төгрөгийн орлоготой 67 (17%), 300 саяас 1.0 тэрбум төгрөгийн орлоготой 69 (17%), 50.0-300.0 сая төгрөгийн орлоготой 61 (15%), 50 сая төгрөгөөс доош орлоготой 20 (5%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо (Хүснэгт 4).

Ажиллагсдын тооны ангиллаар харвал 1-9 болон 10-49 ажилтантай тус бүр 153 (38%), 50-200 хүртэл ажилтантай 63 (16%), 200-с дээш ажилтантай 35 (9%) аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдлаа (Хүснэгт 5).

Хүснэгт 1. Аж ахуйн нэгжийн тоо, өмчлөлийн хэлбэрээр

Өмчлөл	тоо	хувь	Туршлага	тоо	хувь
ХХК	377	93%	5 хүртэл	14	3%
ХК	17	4%	5-10 хүртэл	48	12%
Бусад	10	2%	10-15 хүртэл	59	15%
Нийт	404	100%	15-20 хүртэл	104	26%
			20-с дээш	179	44%
			Нийт	404	100%

Хүснэгт 2. Аж ахуйн нэгжийн тоо, туршлагаар (жил)

Хүснэгт 3. Аж ахуйн нэгжийн тоо, ерөнхий салбараар

Ерөнхий салбар	тоо	хувь	Борлуулалтын орлого	тоо	хувь
Аж үйлдвэр	138	34%	50 сая₮ хүртэл	20	5%
Барилга	63	16%	50-300 сая₮ хүртэл	61	15%
Дотоод худалдаа	65	16%	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	69	17%
Үйлчилгээ	138	34%	1-2.5 тэрбум₮ хүртэл	67	17%
Нийт	404	100%	2.5 тэрбум₮ дээш	187	46%
			Нийт	404	100%

Хүснэгт 4. Аж ахуйн нэгжийн тоо, орлогоор

Хүснэгт 5. Аж ахуйн нэгжийн тоо, ажиллагсдын тоогоор

Ажиллагсдын тоо	тоо	хувь	Хэмжээний ангилал	тоо	хувь
1-9	153	38%	Бичил	81	20%
10-49	153	38%	Жижиг	69	17%
50-200	63	16%	Дунд	67	17%
200-с дээш	35	9%	Том	187	46%
Нийт	404	100%	Нийт	404	100%

Хүснэгт 6. Аж ахуйн нэгжийн тоо, хэмжээний ангиллар

VI. ХАВСРАЛТ 2: Аргачлалын тайлбар

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн болон хэрэглэгчдийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын аж ахуйн нэгж, хэрэглэгчдээс сонгогдсон асуултуудад өгсөн хариултуудын жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Аж үйлдвэр (жин 40%), үйлчилгээ (30%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), барилгын салбарууд (5%) хамаарна. Аж үйлдвэрийн салбараас тухайн улирлын *шинэ захиалга, бэлэн бүтээгдэхүүний нөөц*, ирэх улирлын *үйлдвэрлэл*, барилгын салбараас тухайн улирлын *шинэ захиалга*, ирэх улирлын *ажил эрхлэлт*, дотоод худалдааны салбараас тухайн улирлын *борлуулалтын орлого, худалдан борлуулах барааны нөөц*, ирэх улирлын *борлуулалтын орлого*, үйлчилгээний салбараас тухайн улирлын *бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал, шинэ захиалга*, ирэх улирлын *борлуулалтын орлого*, хэрэглэгчдээс тухайн улирлын *санхүүгийн байдал*, ирэх улирлын *санхүүгийн байдал, хэрэглээ* болон *эдийн засгийн нөхцөл байдал* зэрэг үзүүлэлтүүдийг асууж, асуулт тус бүрийн эерэг сөрөг хариултуудын нийт хариултад эзлэх хувийн зөрүүгээр тодорхойлсон болно.

Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт (EEI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь судалгаанд хамрагдсан дөрвөн үндсэн салбарын аж ахуйн нэгжүүдийн хүлээлтийн жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 23%), барилга (8%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (18%), үйлчилгээний салбарууд (51%) хамаарна. ААН-үүдээс *ирэх улирлын ажил эрхлэлт* хүлээлтийн өөрчлөлтийг судалж, “Өснө”, “Буурна”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт (EUI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Ажлын эрхлэлтийн хүлээлтийн индекс нь аж ахуйн нэгжийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын өгсөн хариултуудын жигнэсэн дунджаар тооцогдоно. Аж үйлдвэр (жин 40%), барилга (5%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), үйлчилгээний салбарууд (30%) хамаарна. ААН-үүдээс *өнгөрсөн улирлын тодорхой бус байдлын* талаарх өөрчлөлтийг судалж, “Өссөн”, “Буурсан”, “Мэдэхгүй”, “Хэвэндээ” гэсэн дөрвөн хариултын эерэг/сөрөг балансаар тодорхойлсон болно.

Медиан утга (Symmetric Linear Interpolated Median)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо тоон асуулгын хариултаас Nicholas J. Cox (2009)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно. Хүлээлтийн утгыг тооцохдоо ХҮИ-д тулгуурлаж байгаа тул үнийн ерөнхий хандлагыг харуулна. Энэхүү тооцсон хүлээлтийн утга нь инфляцын утгыг шууд илэрхийлэхгүй болно.